



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Гимнастикийн Үндэсний шигшээ багийн
бүрэлдэхүүнийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гимнастикийн Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралтаар баталсугай.


2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган тус хуулийн 8 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахыг Монголын гимнастикийн холбоонд үүрэг болгосугай.

3. Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Монголын гимнастикийн холбоонд шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн агентлагийн ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142411109

Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2024 оны ..01 дүгээр сарын 30..
ний өдрийн .137. дугаар тушаалын
хавсралт



ГИМНАСТИКИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН 2024 ОНЫ
БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог	Нэр	Албан тушаал	Төрөл
1	Даваасүрэн	Оюунтуяа	Дасгалжуулагч	Спортын гимнастик
2	Дамдиндорж	Энхтүвшин	Тамирчин	Спортын гимнастик
3	Баярсайхан	Болдбаатар	Тамирчин	Спортын гимнастик
4	Эрхэмбаяр	Өсөхбаяр	Тамирчин	Спортын гимнастик
5	Мөнхцог	Ариунбулаг	Тамирчин	Спортын гимнастик
6	Эрдэнэбаяр	Лхагвацэцэг	Тамирчин	Уран сайхны гимнастик
7	Нарангэрэл	Анужин	Тамирчин	Уран сайхны гимнастик

---oOo---